



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/113


Сүхбаатар сум

Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г", Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд Сүхбаатар сумын 4, 6, 8 дугаар багийн нутаг дэвсгэрт эзэмшүүлэхээр тусгагдсан нийт 4573 м² талбай бүхий 9 байршлын газрыг эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохион байгуулсугай.
2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны тов, тухайн нэгж талбарын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, хугацаа, дэнчингийн хэмжээг нэгж талбар бүрээр энэхүү захирамжийн хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг төвлөгдсөн хугацаанд журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 07 сарын 02-ны өдрийн
А/13 тоот захирамжийн 1-р хавсралт

МНЭА0005 503 013

Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил

№	Дуудлага худалдаанд орох нэгж талбар		Дуудлага худалдааны тов	Дуудлага худалдааны анхны үнэ/төг/	Дуудлага худалдааны хэлбэр	эзэмших Хугацаа	Дуудлага худалдааны дэнчингийн хэмжээ /төг/
	Байршил	Хэмжээ /м2/					
1	Орхон 6 дугаар баг Дэлгэрхаан 1-р гудамж	46	Худалдаа үйлчилгээ	220800	Цахим	15	22080
2	Баян хан 4-р баг Цагаан эрэл 7-р гудамж	194	Худалдаа үйлчилгээ	931200	Цахим	15	93120
3	Орхон 6-р баг 6-р багийн кубоны баруун талд	76	Худалдаа үйлчилгээ	364800	Цахим	15	36480
4	Буур хээр 8-р багийн Буурын гол 1-р гудамж	3000	Худалдаа үйлчилгээ	14400000	Цахим	15	1440000
5	Баян хан 4-р баг Буурын гол 1-р гудамж	500	Худалдаа үйлчилгээ	2400000	Цахим	15	240000
6	Баян хан 4-р баг Буурын гол 1-р гудамж	477	Худалдаа үйлчилгээ	2289600	Цахим	15	228960
7	Баян хан 4-р баг ОУ-ын худалдааны төвийн баруун талд	156	Худалдаа үйлчилгээ	748800	Цахим	15	74880
8	Орхон 6-р баг Дэлгэрхаан 1-р гудамж	68	Худалдаа үйлчилгээ	326400	Цахим	15	32640
9	Орхон 6-р баг Дэлгэрхаан 1-р гудамж	56	Авто засвар	268800	Цахим	15	26880
НИЙТ ДҮН				1516800			1591680